



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2018.03.05 № 06/85

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


#### Үүрэг, хариуцлага

Хэрлэн сумын ЗДТГ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

0900541

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон  
Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,  
Санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор  
Утас: 70562112  
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 70562147  
Цахим хаяг: otuya\_099@yahoo.com

Аудитор: Ц.Хатанболд  
Утас: 70562147  
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг  
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн  
сум 3-р баг АЗДТГ-ын байр  
Цахим хуудас:  
Khentii@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

## Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

123

**Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын ЗДТГ-ын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд *IXЭА-2018/28/СТА-ТШЗ* аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Ц.Хатанболд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэрлэн сумын ЗДТГ-ын төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 19-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 2 дугаар сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 05-нд байгууллагын удирдлагад гардуулна.

**Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, МУ-ын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын ЗДТГ үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай

144  
удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Хэрлэн сумын ЗДТГ-ын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын төрийн сангаар дамжуулан олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаар хангалтгүй байна.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хэнтий аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах,

145  
төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 642,9 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 640,3 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1,7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, тухайн жилийн төсөвт орсон төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 7 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Засаг даргын нөөц хөрөнгийн үлдэгдлийг баримтлаж ажилаагүй, урьдчилгааг цалингийн зардалд хаасан, анхан шатны баримтын дагуу бүртгэл хөтлөөгүй, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн нь эрх ба үүрэг, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

### Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь заалтыг барьж ажилаагүй 7,5 сая төгрөгийн үлдэгдлийг бүрэн зарцуулсан. цалингийн урьдчилгааны үлдэгдэл 0.2 сая төгрөгийг зардалд хаасан, анхан шатны баримтын дагуу бүртгэл хөтлөөгүй 1.6 сая төгрөг нийт 9.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Авлага өр төлбөрийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 2.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3. Бараа материалын зарцуулалтыг шалгахад төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан 1.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

116

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын

талаарх тайлбар:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6 алдаа илэрсэн нь материаллаг бус санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулга хийгдээгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 804,1 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн ба Засаг даргын нөөц хөрөнгийн үлдэгдлийг баримтлаагүй, ажилаагүй, урьдчилгааг цалингийн зардалд хаасан, анхан шатны баримтын дагуу бүртгэл хөтлөөгүй, төсвийг аривлан хэмнэлтгүй зарцуулсан, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй зэрэг нийт 804,1 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж 1 зөвлөмж өгсөнийг 50 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэрлэн сумын ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 13 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг

Хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР


АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД

Бэлтгэсэн:



Огноо: 2018.03.05



ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Төсвийн зарцуулалтын талаар .....	2
Асуудал 2	
Нягтлан бодох бүртгэлийн талаар.....	3
Асуудал 3	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар....	4

2018 оны 03 дугаар сар

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хэрлэн сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

## Илрүүлэлт:

1. Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журамын 2.3 дахь заалтыг барьж ажилаагүй 7,5 сая төгрөгийн үлдэгдлийг бүрэн зарцуулсан. Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамыг зөрчсөн нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Цалингийн урьдчилгааны үлдэгдэл 0.2 сая төгрөгийг зардалд хаасан байна. Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын НББ-ийн дансны заавар зөрчсөн нь эрх ба үүрэг, толилуулга ба илчлэл тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
3. Анхан шатны баримтын дагуу бүртгэл хөтлөөгүй 1.6 сая төгрөг нийт 9.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчсөн нь эрх ба үүрэг, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.
4. Бараа материалын зарцуулалтыг шалгахад төсвийг аривлан хэмнэлтгүй зарцуулсан 1.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь ЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоолыг зөрчсөн байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх  
 Журам зааврыг мөрдөөгүй байх  
 Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

## Зөвлөмж:

1. Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагын НББ-ийн дансны заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн холбогдох заалтыг тус тус мөрдөж ажиллах
2. Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах

## Төсвийн захирагчийн харцуу:

**Илрүүлэлт:**

1. Авлага ер төлбөрийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 2.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтыг мөрдөж тогтоосон хугацаанд тооцооны үлдэгдлийг бүрэн баталгаажуулж байх

**Эрсдэл:**

НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх  
Журам зааврыг мөрдөөгүй байх  
Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

**Төсвийн захирагчийн хариу:**

**Илрүүлэлт:**

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын 257.5 сая төгрөгийн 2 мэдээллийг дутуу мэдээлсэн, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 533.0 сая төгрөгийн 4 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.1, 6.1.5, 6.1.1 гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Зөвлөмж:**

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, 6.1.1, 6.3.5, 6.4.7 заалтыг бүрэн хэрэгжүүлж мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол үнэн зөв мэдээлж байх

**Эрсдэл:**

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

**Төсвийн захирагчийн хариу:**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

**БЭЛТГЭСЭН:**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

Огноо: 2018-03-05

Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Ц.ХАТАНБОЛД